



# LEGAL NEWSLETTER

2026.06.15

№64

AKP Law Firm

Бид 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх батлагдсан онцлох хууль, тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

## I. ХУУЛЬ ТОГТООМЖ:

### 1.1 Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай

Бидний өмнө мэдээллэж байсан хуулийн төсөл болох дотоодын газрын тосны хэрэглээний 55 хувийг хангах чадвартай газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг гадаад зээлийн эх үүсвэрээр барих зэрэг дэд бүтцийн стратегийн томоохон төслүүд хэрэгжих талаарх зохицуулалт агуулсан “Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай” хууль 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан байна.

### 1.2 Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль

Монгол Улсын Их Хурал 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр уг хуулийг баталсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байна. Хуулиар нийслэл, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны удирдлагын бүтэц, чиг үүрэг, харьяалал, санхүүгийн үндсийг шинэчлэн тогтоосон. Хот нь Зөвлөл болон Захирагчийн удирдлагатай, өөрийн төсөв, өмч, газар эзэмшилтэй, орон нутгийн татвар тогтоох эрхтэй нийтийн эрх зүйн этгээд болохыг хуульчиллаа. Улсын зэрэглэлтэй хот нь 100,000-аас доошгүй, орон нутгийн зэрэглэлтэй хот нь 30,000-аас доошгүй оршин суугчтай байхыг шаардлага болгосон бөгөөд хотын Зөвлөл болон Захирагчийг тухайн хотын оршин суугчдаас сонгон 4 жилийн хугацаагаар томилно.

### 1.3 Хотын албан татварын тухай хууль

Мөн өдөр батлагдсан энэ хуулиар нийслэл болон бүх шатны хотуудад 0–2 хувийн хотын албан татварыг нэвтрүүлсэн. Татвар нь бүх

амралтын газар, ресторан, баар, автомашин угаалга болон авто үйлчилгээ зэрэг үйлчилгээ авсан этгээдэд ногдоно. Татварын хувь хэмжээг байршил болон хүн амын нягтаршилийг харгалзан тухайн хотын Зөвлөл тогтоох бөгөөд борлуулагч тухай бүр суутган авч, дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлэх үүрэг хүлээнэ.

### 1.4 Хэлэлцээр соёрхон батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр 2026 оны 05 сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” хэлэлцээр батлагдсан байна.

## II. УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ

### 2.1 Буцаагдсан хуулийн төслүүд

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Байнгын хороонд, 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор “Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг хууль санаачлагчид тус тус буцаасан байна.

### 2.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 15 дугаар тогтоолоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч байгаа хүний эрхийн зөрчил, цагдан хорих арга хэмжээний хэтрүүлэн хэрэглэлт зэргийг системийн шинжтэй доголдол мөн болохыг албан ёсоор тэмдэглэв. Тогтоолоор Засгийн газарт өмгөөлөгчгүйгээр байцаалт явуулахыг зогсоох, цагдан хорих арга хэмжээний хэрэглээг хязгаарлах, эрүү шүүлтээр авсан мэдүүлгийг

нотлох баримтаар тооцохгүй байх зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэсэн бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны шүүхийн хяналтыг бэхжүүлэх, прокурор болон өмгөөлөгчийн тэгш байдлыг хангах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан алба байгуулах чиглэлийн хуулийн төслийг 2026 оны намрын чуулганд өргөн мэдүүлэхийг даалгасан байна.

### **III. ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦЛОХ ТОГТООЛ**

2026 оны 06 дугаар сарын эхний 2 долоо хоногт нийт 10 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

#### **3.1 Улаанбаатар хот өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжлээ**

Монгол Улсын Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 235 дугаар тогтоолоороо Нийслэл Улаанбаатар хотын эрчим хүчний салбар болон засаг захиргааны байгууллагуудыг 2027 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэв. Үндэслэл нь агаарын бохирдуулагч бодисын агууламж стандартын хүлцэх хэмжээнээс давсан, мөн өвлийн их ачааллын үед эрчим хүчний хүчин чадлын дутагдал үүсэх эрсдэл нэмэгдсэн явдал юм.

Тогтоолын дагуу Нийслэлийн Засаг дарга агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхийн хэрэглээнд зориулсан хагас коксон түлшний нийлүүлэлт, чанар, стандартад хяналт тавих үүрэг хүлээсэн бол Эрчим хүчний сайд эрчим хүчний салбарын арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ. Тогтоолын хэрэгжилтэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хяналт тавина.

Тогтоол нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон Агаарын тухай хуулийн холбогдох заалтуудад тулгуурласан бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдал 2027 оны хаврын улирал хүртэл үргэлжилнэ.

#### **3.2 Хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээ e-business.mn-д нэгтгэгдэнэ**

Монгол Улсын Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 233 дугаар тогтоолоороо

төрөөс хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээг "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-business.mn)"-ээр дамжуулан цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох яам, агентлаг, орон нутгийн захиргаануудад даалгалаа.

Тогтоолын дагуу хуулийн этгээд байгуулах болон татан буулгах хүсэлтийг цаашид e-business.mn-ээр хүлээн авч шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд даалгасан байна. Мөн системийн шинэчлэгдсэн 2.0 хувилбарыг 2026 оны 06 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөжээ.

Энэхүү шилжилт нь Монгол Улсад компани байгуулах, үйл ажиллагааны зөвшөөрөл авах зэрэг бүртгэлийн үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх томоохон алхам болж байна.

### **IV. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

#### **4.1 Нийслэлд барилгын ажлын аюулгүй ажиллагааны шинэ журам батлагдлаа**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр А/623 дугаар захирамжаараа "Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ыг баталлаа. Тус журмыг Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд барилгын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд бүр уг журмыг дагаж мөрдөх үүрэгтэй ба журмын хэрэгжилтэд Нийслэлийн Хяналт шалгалтын газар болон дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээсэн байна.

Тус журмаар Барилгын ажлын зохион байгуулалт, барилгын ажил эхлэхийн өмнө ба ажил гүйцэтгэлийн явц болон барилга байгууламжийг буулгахад тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагуудыг нарийвчлан зохицуулсан байна.

#### **ALISON & KATE PARTNERS**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3  
давхар, 301/a  
Web: www.akp.mn  
E-mail: contact@akp.mn  
Tel: 7704-1414, 8013-0414